



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/510

Алтай хот

“Алтайн залуус-2022” Есөнбулаг сумын
залуучуудын чуулган, арга хэмжээ зохион
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2, 10.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.7.1 дэх заалт, Удирдлагын зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, нийгэм дэх тэдний оролцоог дэмжих зорилгоор “Алтайн залуус-2022” Есөнбулаг сумын залуучуудын чуулган, арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 12, 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулж, удирдамж хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 38,200,000 (гучин найман сая хоёр зуун мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20²² оны 08
дугаар сарын 11-ны өдрийн 151 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

“АЛТАЙН ЗАЛУУС-2022” ЗАЛУУЧУУДЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Үндэслэл:

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 10 дугаар зүйлийн 10.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтад заасны дагуу залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, бие даан амьдрах, нийгэм дэх тэдний оролцоог дэмжихэд төрөөс баримтлах чиглэлийн болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.7.1 дэх заалтын хэрэгжилтийг тус тус хангаж, “Алтайн залуус-2022” арга хэмжээг зохион байгуулж байна.

Зорилго:

Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжиж, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт, гэр бүл төлөвлөлт, нийгмийн эрүүл мэнд буюу нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг олгох, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Зорилт:

Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл, амьдрах ухааны чадварыг залуучууд эзэмшинэ.

Залуучуудын дунд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх арга зам, санал, санаачилгыг гаргана.

Залуучуудад амьдрах ухааны болон эрүүл мэндийн эерэг зөв дадал, хандлага төлөвшсөн байна.

Зохион байгуулагч: аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

Хамтран зохион байгуулагч: аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Соёл урлагийн газар, Ардын дуу бүжгийн “Алтай” чуулга, Насан туршийн боловсролын төв, Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар, Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Залуучуудын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо

Хамрах хүрээ: Говь-Алтай аймгийн 18 сумын залуус

Хугацаа, хаана: 1.2022 оны 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд Алтай хот болон “Дөргөн нуур” жуулчны баазад


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

2022 оны 08-р сарын 10 /Нэгдсэн эмнэлэг/			
Цаг	Үйл ажиллагааны нэр	Хариуцах эзэн	Хамрагдах сумд
08:00-18:00	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношилгоонд хамрагдах	Нийгмийн бодлогын хэлтэс Эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлэг	Есөнбулаг сум /хуваарийн дагуу/
2022 оны 08-р сарын 11 /Нэгдсэн эмнэлэг/			
Цаг	Үйл ажиллагааны нэр	Хариуцах эзэн	Хамрагдах сумд
08:00-18:00	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношилгоонд хамрагдах	Нийгмийн бодлогын хэлтэс Эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлэг	Есөнбулаг сум /хуваарийн дагуу/
2022 оны 08-р сарын 12 /Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгад/			
Цаг	Үйл ажиллагааны нэр	Хариуцах эзэн	Чиглүүлэгчийн нэр
07:00-07:30	Оролцогчдын бүртгэл	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Б.Алтайбаатар
08:00-08:30	Нээлтийн арга хэмжээ, Үйл ажиллагааны хөтөлбөр, сургалтын дэг, танилцуулга хийх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	П.Хулан
08:30-09:30	Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар үйл ажиллагааг нээж, оролцогчдод хандан үг хэлнэ	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	П.Хулан
09:30-10:00	"Хүн амын бодлого, суурьшил"	Монголын хүн амын судалгааны голлох эрдэмтдийн нэг, Профессор	Профессор О.Сүхбаатар
10:00-10:30	"Гэр бүлийн үнэт зүйл" /цахимаар/	Гэр бүл судлаач, Шинжлэх ухааны доктор, профессор	Боржигин-Тулга овог Төмөр-Очирын Намжил
10:30-11:00	"Нийгмийн эрүүл мэнд буюу нөхөн үржихүйн эрүүл мэнд"	Уламжлалт анагаах ухааны төвийн захирал, Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн их эмч	Б.Сэргэлэн
11:00-11:30	"Цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол"	Үндэсний сургагч багш, Тогтвортой хөгжлийн боловсролын мастер	Г.Лувсандагва
11:30-12:00	Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан-Бизнесийн боломж	Хүнс хөдөө аж ахуйн газар	Т.Сүхбаатар
12:00-12:30	Дүгнэлт, сургалтын хаалтын үйл ажиллагаа	ГБХЗХГазар	Б.Алтайбаатар


12:30-13:30	Үдийн хоолны завсарлага	Спорт цогцолборт	Д.Хандсүрэн Т.Баярзул
13:30-17:30	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношилгоонд хамрагдах	Нийгмийн бодлогын хэлтэс Эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлэг	Бүх сумд /хуваарийн дагуу/
17:30-18:00	Төв талбайд цуглах (Багийн хуваарилалт)		
18:00	Дөргөн нуур жуулчны бааз руу хөдлөх, зааварчилгаа өгөх	Хуваарийн дагуу	Н.Ууганбат Э.Мэндсайхан Р.Наранбаатар
22:30	Жуулчны баазад байрлах		
23:00	Оройн хоол	Тогооч нарын холбоо, Хөхморьт сумын ЗДТГ	
23:30	Movie night	Ажлын хэсэг	Т.Баярзул Э.Туул
00:00	Оройн тоо, унтлагын цаг	Ажлын хэсэг	Т.Мөнх-Амар М.Даваабаяр Ж.Баасанцэрэн
2022 оны 08-р сарын 13 /Хөхморьт сум, Дөргөн нуур жуулчны бааз/			
07:00-08:00	Хувийн бэлтгэлийн цаг	-	-
08:00-08:30	Өглөөний дасгал (флашмоб)	Эмэгтэйчүүдийн холбоо	З.Сарантуяа-Зумба фитнесийн багш, дасгалжуулагч, Дэлхий аваргын хошой хүрэл медальт
08:30-09:00	Өглөөний цай	Ажлын хэсэг	П.Хулан
09:00-18:00	Сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх	Ажлын хэсэг	Т.Баярзул
10:00-13:00	Өртөөчилсөн сургалт эхлэх	Ажлын хэсэг	М.Даваабаяр
13:00-14:30	Үдийн хоол	Ажлын хэсэг	П.Хулан
14:30-16:30	Өртөөчилсөн сургалт үргэлжлэх	Ажлын хэсэг	М.Даваабаяр
16:30-18:30	"Durgun Youths festival" тэмцээн	Залуучуудын холбоо	Аймгийн Залуучуудын холбоо Ё.Хатанбаатар
18:30-19:00	Тэмцээний шагнал урамшуулал	Тусгай хөтөлбөрөөр	Аймгийн Залуучуудын холбоо Ё.Хатанбаатар
19:00	Оройн хоол	Ажлын хэсэг	П.Хулан

21:30	"Light Night & Date Night" үдшийн арга хэмжээ (тусгай хөтөлбөрөөр)	Залуучуудын холбоо, Ардын дуу бүжгийн "Алтай" чуулга	Т.Мөнх-Амар М.Даваабаяр Б.Жаргалсайхан
2022 оны 08-р сарын 14 /Хөхморьт сум, Дөргөн нуур жуулчны бааз/			
07:00- 08:00	Хувийн бэлтгэлийн цаг		
08:00- 08:30	Өглөөний дасгал (флашмоб)	Эмэгтэйчүүдийн холбоо	З.Сарантуяа- Зумба фитнесийн багш, дасгалжуулагч, Дэлхий аваргын хошой хүрэл медальт
08:30- 09:00	Өглөөний цай	Ажлын хэсэг	
Аймгийн төв, сумдын зүг хөдлөх			

__оОо__



Аймгийн Засаг даргын 2022 оны 08
дугаар сарын 11-ны өдрийн 1/510 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Цайны завсарлага-1 өглөөний цай-2 Үдийн хоол-1 Оройн хоол-2	350	68,000	23,800,000
3.	Алтай хот-Дөргөн нуур-Алтай хот ирж очих автомашины шатахууны зардал (2 талдаа нийт 600 км)	20 автомашин	620,000	12,400,000
4.	Жуулчны баазын төлбөр	10 гэр*2 өдөр	100,000	2,000,000
Нийт зардал				38,200,000

__оОо__